



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/46.

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын 2021-2023 онд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын 2021 оны сургалтын төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүр сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу ажиллагсдыг сургалтад жигд хамруулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Дашпүрэв/-т үүрэг болгосугай.

3. Сургалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, хамтран ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс /Б.Буянзаяа/-т үүрэг даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2020 оны 08 дүгээр / дугаар сарын 26 -ний/ны өдрийн
... дугаар /дүгээр/ тушаалын хавсралт
А/46.

Д/д	Сургалт зохион байгуулах байгууллага	Сургалтын чиглэл	Хамрагдах тоо	Төлбөр /төгрөг/
1	ШУТИС, МУИС	Мэргэшсэн инженерээр зэрэг олгох сургалтууд	6	4,800,000
2	Удирдлагын академи, ШУТИС, МУИС	Магистр, докторын зэрэг олгох сургалтууд	7	21,000,000
3	"Худалдан авах ажиллагааны хөтөч" төрийн бус байгууллага	/АЗ/ Худалдан авах ажиллагааны сургалт	16	1,200,000
4	Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг	Шинэчилсэн найруулагатай холбоотой чиглүүлэх сургалт	1	1,500,000
5	Удирдлагын академи	Богино болон дунд хугацааны багц сургалтууд	28	Удирдлагын академи зардлыг хариуцна.
6	Авлигатай тэмцэх газар	Авлигын эсрэг хор хөнөөл, хүнд суртал, чирэгдэл, албан тушаалын гэмт хэрэг сургалтууд	125	АТГ зардлыг хариуцна.
	ДҮН /төгрөг/		183	28,500,000

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2024 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн
А/116 дугаар /дүгээр/ тушаалын хоёрдугаар хавсралт

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад байгууллагын стратегийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэх, төрийн албан хаагчдыг дахин мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, цаг үеийн шаардлагад нийцсэн, өндөр боловсрол, мэдлэг чадвар, ёс зүйтэй албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэх, хөрвөх чадвартай боловсон хүчин бэлтгэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

- 2.1. Агентлагийн албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар дээшлүүлэх.
- 2.2. Дотоодын боловсролын байгууллагуудад албан хаагчдаа сургаж, мэргэшүүлэх /мэргэшсэн, зөвлөх мэргэжилтэн болох/ мэргэжил дээшлүүлэх /мастер-доктор/, дадлагажуулах, ажлын байран дахь сургалтад хамруулах
- 2.3. Шинээр томилогдсон ажилтнуудыг анхан шатны буюу баримжаа олгох сургалтад хамруулах.
- 2.4. Сургалтын төлөвлөгөөг /мастер, жилийн/ тодорхой хугацаатай боловсруулан батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулж хэвшүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

- 3.1. Агентлагийн үндсэн чиг үүрэгтэй холбоотой сургалтад байгууллагын албан хаагчид жигд хамрагдсан байх.
- 3.2. Төрийн жинхэнэ албан хаагчийг гадаадад сургахдаа гадаад хэлний мэдлэг, салбарт ажилласан хугацаа, ажлын үр дүн болон одоо эрхэлж буй ажлын чиг үүрэг нь сургалтын хөтөлбөртэй нийцэж буй эсэхэд үндэслэх.
- 3.3. Дахин сургалтад хамрагдах албан хаагчийн сургалтын хэлбэр, түвшин ахисан байх.
- 3.4. Агентлагийн албан хаагчдын сургалтын хэрэгцээ, шаардлагыг судалж, хэлтэс нэгжүүдээс ирүүлсэн санал, захиалгыг үндэслэн сургалтын төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулах.
- 3.5. Сургалтын хөтөлбөр, журам, төлөвлөгөө, сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээлэл нээлттэй ил тод байх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага зохион байгуулалт

- 4.1. Энэхүү хөтөлбөрийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд жил бүрийн 12 дугаар сард багтаан өмнөх жилийн хэрэгжилтийг хэлэлцэж, хэлтэс нэгжүүдээс ирүүлсэн сургалтын хүсэлтийг үндэслэн дараа жилийн сургалтын төлөвлөгөөг батална.
- 4.2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /ТЗУХ/ мэргэжлийн хэлтсүүдтэй хамтран зохион байгуулна.
- 4.3. Урт хугацааны сургалтад хамрагдах төрийн албан хаагч нь ТЗУХ-ийн даргатай “Урт сургалтын гэрээ” байгуулна.
- 4.4. Ажилтан нь өөрийн хүсэлтээр, эрхэлсэн ажлаасаа өөр чиглэлээр мэргэжил эзэмшихээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй сургалтад суралцах хүсэлтэй бол байгууллага зардлыг хариуцахгүй.
- 4.5. Хариуцсан ажил, албан үүргээ онцгой сайн биелүүлж төр засгийн шагналаар шагнагдсан, тэргүүний ажилтнаар шалгарсан албан хаагч өөрөө хүсвэл мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж шалгуурыг харгалзахгүйгээр зохих сургалтад хамруулж, сургалтын төлбөрийг болон зардлын тодорхой хувийг Агентлагаас гаргаж урамшуулж болно.
- 4.6. Төрийн албан хаагчийг сургалтад хамруулах, санхүүжилтийн асуудлыг тухайн жилийн төсөв, сургалтын төлөвлөгөөнд тусган батлуулах.
- 4.7. Агентлагийн төрийн албан хаагчдын дотоод, гадаадын урт, дунд, богино хугацааны сургалтад хамрагдах хүсэлтийг Агентлагийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргана. Уг асуудалтай холбогдуулан гаргасан санал, өргөдөл, гомдлыг ТЗУХ хүлээн авч, холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

- 5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:
 - 5.1.1. Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсвөөс, Монгол Улсын засгийн газраас гэрээлэгч компаниудтай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу газрын тосны хайгуул олборлолтын ажил гүйцэтгэж буй гадаад, дотоодын компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөнөөс зардлаас санхүүжүүлнэ.
 - 5.1.2. Гадаад улс, олон улсын байгууллага буюу хүлээн авагч талын хөрөнгөөр Гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр болон бусад зардлаас санхүүжүүлнэ.

Зургаа. Хяналт шинжилгээ үнэлгээ

- 6.1. Сургалтын хөтөлбөр, журам, төлөвлөгөөний хэрэгжилтэд Хяналт, шинжилгээ, үнэлгээ статистик хариуцсан хэлтэс хяналт тавьж ажиллана.
- 6.2. Урт хугацаагаар суралцах эрх авсан албан хаагчдын сургалтад тавих хяналтыг энэхүү Хөтөлбөрийн 4.3-т заасан гэрээгээр зохицуулна.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

7.1. Албан хаагчдын боловсролын зэрэг, мэргэжлийн ур чадварыг харгалзан мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх, онолын мэдлэгийг сайжруулах, давтан сургалтын үе шаттай бодлогыг хэрэгжүүлснээр ажиллагсад эрхэлсэн ажилдаа дадлагажих, шинэ арга барилыг нэвтрүүлэх, амжилт үр бүтээл гаргах боломж бүрдэж, ажилд ахиц дэвшил гарна.

7.2. Мэдлэг, чадвартай мэргэшсэн албан хаагчидтай болсноор төрийн байгууллагын чадавх дээшилж, чиг үүргийн хүрээнд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөл бүрдэнэ.

7.3. Агентлагийн хэмжээнд төрийн албан хаагчдыг бэлтгэх, давтан сургах тогтолцоо бүрдсэнээр төрийн албан хаагчид байнга суралцан хөгжих боломж, нөхцөлөөр хангагдана.

7.4. Төрийн албан хаагчдын манлайлал өндөр түвшинд хүрнэ.

---oOo---